

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Улиасны модожсон мөчрийн тайраадас. Ерөнхий шаардлага	MNS 1796 : 2011 MNS 1796 : 1973-ын оронд
Wooden branch cutting of Poplar. General requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь мод үржүүлгийн газар ба эх ургамлын талбайд ургуулах улиасны модожсон мөчрийн тайраадас бэлтгэх, шалгаж хүлээн авахад хамаарна.

2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 6141 : 2010, Навчит төрлийн модны суулгац, Техникийн шаардлага,
- ГОСТ 17267-71, Улиасны мөчир. Техникийн шаардлага,
- Ойн нэр томъёоны товч тайлбар, 2010.

3 Нэр томъёо, тодорхойлолт

3.1

Модожсон мөчир

Тухайн жил шинээр ургасан нэг настай найлзуур,

3.2

Тайраадас

Ургал эрхтнээр ургуулах зорилготой нэг настай ургамлын хэсэг эрхтэн,

4 Ангилал

Улиасны модожсон мөчрийн тайраадас нь ишний бүдүүн, уртаар нь:

- I зэрэг
- II зэрэг гэж 2 ангилна.

5 Техникийн шаардлага

Улиасны модожсон мөчрийн тайраадсыг том модны мөчир, хожуулын буюу үндэсний ичмэл нахианаас ургасан 1 настай мөчрөөс тайрч бэлтгэнэ. Түүнчлэн хот суурин газруудын тохижуулалтад хэрэглэж буй модыг танаж, засахад гарсан мөчрөөс бэлдэнэ.

Д/д	Нэр	Зэрэг	
		I	II
1	Улиасны модожсон мөчрийн тайраадсны бүдүүн, мм-ээр	10-12	5-9
2	Улиасны модожсон мөчрийн тайраадсны урт, см-ээр	25-30	20-25


5.2 Тайраадас бүр 5-аас доошгүй нахиатай байна.

5.3 Тайраадасны нахианууд нь гэмтэлгүй, хортон шавьжинд нэрвэгдээгүй байна.

5.4 Улиасны модожсон мөчрийн тайраадас бүдүүнээрээ тухайн зэрэгт таарч байлаа ч гэсэн түүний 1-ээс 2 нахиа нь гэмтсэн байвал II-р зэрэгт хамааруулна.

5.5 Удамшлын сонголт хийгдсэн модноос бэлтгэсэн I-р зэргийн тайраадсаар эх ургамлын талбайг байгуулна.

5.6 Улиасны суулгац ургуулах улиасан ойг тарихад I, II-р зэргийн тайраадсыг ашиглана.



1-р зураг. Тайраадсын тайралт

6 Улиасны модожсон мөчрийн тайраадас бэлтгэх, хадгалах, тээвэрлэх

6.1 Улиасны модожсон мөчрийг хавар модны нахиа задрахаас өмнө 3-аас 4-р сард, намар модны навч унаж өсөлт нь зогссон 9-өөс 10-р сард бэлтгэнэ.

Тайраадас бэлтгэх үед нахиаг нь хугалах, холтсыг шалбалж гэмтээхийг хориглоно.

6.3 Шаардлагын дагуу бэлдсэн улиасны тайраадсыг стандартын дагуу зэрэглэнэ.

6.4 Тайраадсыг бэлтгэхдээ дээд нахианаас 0,5-аас 1 см зайд тэгшхэн, доод талын нахианаас 1-ээс 1,5 см зайд ташуу хэрчинэ.

ТАЙЛБАР: Тайраадсны дээд үзүүрийн хэрчээсийг тарихын өмнөхөн буюу дараа нь шинэтгэж болохгүй. Харин доод талын хэрчлээсийг тарилтын өмнө шинэтгэх хэрэгтэй.

6.5 Зэрэг тогтоосон мөчрийн тайраадсыг 50-аас 100 ширхэгээр нь багцлан боож, урьдаас бэлдсэн тусгай мөсөн зоорь, шуудуунд хийн, чийгтэй элс, цасанд дарж суулгах хүртлээ хадгална.

- 6.6** Ил талбайд хадгалж буй тайраадсны хучаасыг нар салхины нөлөөнөөс хамгаалахын тулд брезент, сүрэл, зэгсээр бүтээнэ.
- 6.7** Хол тээвэрлэх тайраадсыг хайрцаганд хийж, чийгийг алдуулахгүйгээр шороо, үртсээр хучина.
- 6.8** Тайраадсыг нойтон, зузаан цаасанд ороож, нийлэг эдлэлд боож хийгээд гадуур нь даавуун уут хийж тээвэрлэнэ.
- 6.9** Агаарын дулаан 15°C -ээс 20°C хэм болтол дулаарсанаас хойш тайраадсыг хол газар удаан тээвэрлэж болохгүй. Өвөл, хавар ч гэсэн шуудангаар явуулах тайраадсанд «Хүйтэн газар хадгал» гэсэн бичигтэй явуулна.
- 6.10** Баглаа бүрд улиасны (зүйлийн) нэр, бэлтгэсэн газар, хугацаа зэргийг заасан шошго зүүнэ. Шошгонд эд шалгагчийн тэмдэг дарсан байна.

ТӨГСӨВ.